

Данзангийн Нарантуяа

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн дэд профессор

НИЙГМИЙН СУДАЛГААНД ЗУРАГ АШИГЛАХ НЬ

Abstract: *The paper reads a photography taken in China in 1954 using a methodology that makes sound inferences from the picture itself and the audience under communist leaders. Social documentaries can be used to enhance our research and understanding in new ways. The picture about a distinguished schoolboy from a remote area as an inheritor aims to inculcate the people with the eternity of communism and its ideology.*

Key words: *communism, Inner Mongolia, picture narrative, schoolboy*

Нийгмийн ертөнцийн тусгал, эсвэл баримт болж байгаа гэрэл зургуудыг нийгмийн судалгаанд ихэвчлэн ашигладаг. Дарсан зураг бүр баримт болон үлддэг учир гэрэл зургийг нийгмийн ухаанд баримтын судалгаанд багтаах нь олонтаа. Судалгаанд урд өмнө байсан зургуудыг, эсвэл судалгааны зорилгоосоо хамаарч шинээр авсан зургуудыг ашиглаж болно. Хотын нэг хэсэг, ордог дэлгүүрийнхээ нэг булан, ээж аавынхаа юмуу өөрсдийн эдэлж хэрэглэдэг зүйлс, голын нэг тохой, модтой уулын энгэр зэрэг товлосон зүйлийнхээ зургийг жил дараалан авч, түүнтэй холбоотой жижиг түүхийг бичиж хавсаргасан ч тэдгээр нь айл гэр, хот, нийгэм, байгалд орчинд цагийн аясаар гарсан олон өөрчлөлтүүдийг өгүүлдэг юм.

Харин урд өмнө авсан гэрэл зургийг судалгаанд ашиглаж шинжлэхдээ юу өгүүлж байна, хэзээ, хэн, хэнд зориулж, ямар нөхцөлд яаж авсан, ямар учиртай, юу харуулах гэсэн, хэрэглээ нь юу байв гэх мэт асуултуудыг тавих хэрэгтэй. Ажил хайж цагаачилж гарсан иргэдийн гэр рүүгээ илгээсэн зургуудад хийсэн олон судалгаагаар тэд амьдралаа байгаагаас нь илүүгээр харуулахыг зорьдог гэсэн ойролцоо дүгнэлтүүд гарсан байдаг. Жишээ нь, 1987 оны Шина Кроуфордын судалгаанд Кипр улсаас цагаачилсан хүмүүсийн төрөл садан руугаа явуулсан зургууд тэдний амжилт, амралт, тэмдэглэлт үйл явдал, өмссөн, эдэлснийг үзүүлснээс биш тааламжгүй нөхцөлд олон цагаар ажилласан тухай байгаагүй байна (Loizos, 2000: 101). Нэгэнт зардал гаргаж, илүү орлого олох гэж нутгаасаа гарсан ажил хайгсад ард үлдсэн хүмүүстээ амьдралаа сайн талаас нь харуулсан зургуудаа явуулдаг ажээ. Иймд баримт, гэрэл зургийн бүрэн утга санааг гаргахын тулд хэнд, юу өгүүлэх зорилготой бүтээгдсэнийг мэдэх шаардлагатай байдаг. Айл гэрийн цомогт хүртэл эздийнх нь шилж хийсэн зургууд байдаг ба тэдгээрийн ихэнхийг өнгө төрхөө бэлдэж авахуулсан байдаг. Францын нэрт эрдэмтэн зохиолч Роналд Бартесын хэлснээр дүрс зураг хоёр утга агуулдаг. Үүний нэг нь *ил* буюу үзэгдэх шууд утга, өөрөөр хэлбэл дүрсээр илэрхийлсэн бодит үнэн; нөгөөх нь түүх, соёлтой хамтатгагдсан *давхар* утга ба түүнийг бид өөрсдийн туршлагаараа мэдэж ойлгодог юм хэмээжээ (Weber, 2008:42).

Баримт, гэрэл зургийн бүрэн утга санааг гаргахын тулд хэнд, юу өгүүлэх зорилготой бүтээгдсэнийг мэдэх шаардлагатай байдаг ба гэрэл зургийн илэрхийлэх шууд утга, мөн далд буюу давхар утгыг хэрхэн “уншиж” хөрвүүлэх талаар дараах зургаар өгүүлбэ. Фото хуулбар гэхээсээ зориуд “урласан” гэмээр энэ урт нэртэй сонирхолтой зургийг АНУ-ын Конгрессийн номын сангийн цуглуулгаас олсон юм. “Өвөр Монголын Олончун автономит хошууны бага сургуулийн 4 дүгээр ангийн сурагч Санжмятав багшийнхаа асуултад хариулж байгаа нь” гэсэн дээрх зургийг 1954 онд бүтээжээ. Харин хэнийх гэдгийг тодорхойлж чадсангүй. Номын сангийн лавлагаас асуухад энэ нь анх 1950 онд дугаараа эхэлсэн *China Pictorial* сэтгүүлийн хавтсанд нийтлэгдсэн зураг гэх ба будаж янзалсны дараа гэрэл зурагт буулгасан гэсэн юм. Юуны өмнө зурагт хэн, юу дүрсэлснийг харцгаая. Энэ зургийн гол дүр нь Санжмятав бөгөөд багшийнхаа асуултад хариулж байгаа байдал нь сурлага сайтай, хичээлдээ сайн бэлдсэн сурагч болохыг харуулна. Түүний цаана суугаа охины байдлаар ч гэсэн тэр байнга л сайн хариулдаг гэдгийг тааварлаж болно. Тэд цэвэрхэн, дээл өмсч, улаан бүч зүүсэн байна. Хүүхдүүдийн цаад хананд Сталин, Мао цэ дун нарын зураг өлгөжээ. Зөвлөлт холбоот улс болон Хятадын тэр үеийн удирдагчдыг мэдэхгүй хүн ч гэсэн улс орны удирдагчид гэдгийг тугаар нь, доор нь дүрсэлсэн ард түмний төлөөллөөр түвэггүй таамаглахаар илэрхийлжээ. Ширээн дээр дэвтэр

ном, дүрдэг бэх зэрэг байна. Сургуулийн эерэг талаас нь дүрсэлснийг ангийн хэсэг, хүүхдүүдийн өнгө төрхөөс ажиглаж болно.



Өвөр Монголын Олончун автономит хошууны бага сургуулийн 4 дүгээр ангийн сурагч Санжмятав багшийнхаа асуултад хариулж байгаа нь. 1954 он.

Энэ зургийг 4 дүгээр ангийн сурагч Санжмятав багшийнхаа асуултад сайн бэлдсэнийг л харуулах гэж бүтээв үү эсвэл давхар утга агуулж байна уу гэдгийг одоо магадлая. Коммунист нийгэмд пионерт элсч, улаан бүч зүүх нь сурагчдын нэр төрийн хэрэг бөгөөд бүч нь хувьсгалын улаан тугийг бэлгэддэг. Тэргүүний сурагчид хамгийн түрүүнд пионерт элсэнэ. Зурагт дүрслэгдсэн хоёр сурагч улаан бүчтэй байгаа нь тэд тэргүүний, бас коммунист нийгмийг цогцлоохоор бэлтгэгдэж байгааг илэрхийлэх ажээ. Одоо ханан дахь зураг гол дүртэй хэрхэн холбогдолтойг шинжилье. Удирдагчдын зургийн доор бичигдсэн ханз үсгийг хөрвүүлвэл “Сталин, Мао цээ дун нар ард түмнийг ялалт руу удирдан чиглүүлж байна” гэсэн байх ба зурагт туссан гэрэл тэднийг гэгээрүүлэгч, бурханлиг хүмүүс мэтээр үздэгийг тодотгоно. Коммунизм гэгээлэг, мөхөшгүй, түүний суртал хэрхэн түгэж, түүний ялалтад хойч үе нь яаж бэлтгэгдэж байгааг багшдаа хариулах Санжмятав, нэг ширээнд суусан охин, тэнхимийн орчноор төлөөлүүлэн гаргажээ. Зургийн урт нэрийн учир ч бас тайлагдаж байна. Энэ зураг Сталинг нас барснаас нэг жилийн дараа бүтээгдсэн байх юм. Тэгэхээр удирдагч таалал төгссөн ч дараах үе нь хошуу, гацаанаас ч залгаж төрөх болно гэсэн санааг бас агуулж байгаа юм. Харин залгамжлагч нь эмэгтэй биш эрэгтэй хүүхэд байна. Зураг хаана хэзээ бүтсэнийг дахин нэг санахад энд гайхах зүйл байхгүй. Учир нь тэнд айлын өв хөрөнгө, удам судрыг эрэгтэй хүүхэд л залгамжилдаг билээ. Дүрслэлийн ил утга ба түүх, соёлтой хамтатгагдсан *давхар* утгыг энэ жишээгээр тайлж болно.

Зургийг “уншихдаа” эхлээд бүхэлд нь юуны тухай дүрсэлснийг хардаг, дараа нь хэсэгчилж шинжилнэ, эцэст нь нэгтгээд дүгнэлтээ хийдэг. Өвөр Монголын Олончун хошууны тухайн үеийн түүх соёл, хүн ам, нэр усыг судалвал үүнээс ч илүүг хэлж өгөх нь дамжиггүй. Зургийг хэн ямар зориулалтаар бүтээснийг бас мэдэх нь чухал. Хоёр буюу түүнээс илүү зурагтай ажиллах тохиолдолд тус бүрт нь шинжлэхээс гадна харьцуулж шинжилдэг. Нэг хүний хэд хэдэн бүтээл, олон хүний ижил сэдэвтэй бүтээлийг сонгож болно. Эдгээрийн юу нь төстэй, юу нь ялгаатай байгааг хар, эргэцүүл, эрэлхийл, таамаглалаа дэвшүүл. Тэгээд холбогдолтой баримтуудыг үзэж, хүмүүсээс асууж судлан шинжилгээ хийж дүгнэлтээ гаргана. Гэрэл зургийг түүх, социологи, улс төр, сэтгэл судлал гэх мэт олон салбарт ашиглах боломжтой.

Ашигласан хэвлэл

1. Loizos, P. 2000. ‘Video, Film and Photographs as Research Documents’ in Bauer, M.W. and G.Gaskell (eds.) *Qualitative Researching with Text, Image And Sound: A Practical Handbook*. London: Sage
2. Weber, S. 2008. ‘Visual Images in Research’ in Knowles, J. G and A. L. Cole, [Handbook of the Arts in Qualitative Research: Perspectives, Methodologies, Examples, and Issues](#).